

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 43.020

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага	MNS 5012 : 2011
Service of public transport. Classification and General requirements for services	MNS 5012 : 2008-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 74 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт 2012 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартыг үзүүлэлт, шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх үйлчилгээг зохион байгуулах, нийтлэг шаардлагыг тогтооход төр, захиргааны болон бусад байгууллагаас тавих хяналт болон ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1 Энэхүү стандарт нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлоход хамаарна.

2.2 Уг стандартыг нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, үйлчилгээнд хяналт тавих эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөж хэрэглэнэ.

3 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)–ийг хэрэглэнэ. Үүнд:

- MNS 4598 : 2011, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих техникийн ерөнхий шаардлага
- MNS 4599 : 2003, Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикын үзүүлэлт
- MNS 4601: 2011, Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт”
- MNS 5011 : 2003, Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага
- MNS 5013 : 2009, Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга,
- MNS 5014 : 2009, Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга”

- MNS 5044 : 2010, Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв - ангилал - ерөнхий шаардлага
- MNS 5122 : 2008, Нийтийн таксийн үйлчилгээ. Ангилал ба тодорхойлолт. Ерөнхий шаардлага.
- MNS 5537 : 2005 “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж. Үндсэн шаардлага”
- MNS 5342 : 2007, Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага
- MNS 5831 : 2007, Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага
- MNS 5879 : 2008, Нийтийн тээвэр. Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага
- MNS 6225 : 2010, Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800F загварын Дуобус. Техникийн ерөнхий шаардлага.
- MNS 5773 : 2007, Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800 загварын троллейбус угсрах, ашиглах. Үндсэн параметр ба техникийн ерөнхий шаардлага.

4 Нэр томъёо, тодорхойлолт

4.1 Энэ стандартад хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгож, хэрэглэнэ. Үүнд:

4.1.1

нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ

нийтийн зорчигч /АТҮТ/ тээврийн хэрэгслээр тав тухтай соёлтой, шуурхай үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа.

4.1.2

нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл

зорчигч, тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автобус, такси, цахилгаан тээврийн хэрэгсэл.

4.1.3

зорчигч

нийтийн зорчигч-тээврийн хэрэгслээр зорчих тийз, тасалбар авсан зорчигчийг /АТҮТ/

4.1.4

зорчигч тээвэрлэлт

автотээврийн нийтийн тээврийн /АТҮТ/ хэрэгслээр зорчигчийг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөхтэй холбогдсон ажил, үйлчилгээ

4.1.5

улс хоорондын зорчигч нийтийн /АТҮТ/ тээвэрлэлт

монгол улсын хилийг нэвтрэн хийх зорчигч тээвэрлэлт

4.1.6

хот хоорондын зорчигч нийтийн /АТҮТ/ тээвэрлэлт

хот, аймгуудын нутаг дэвсгэрийг дамжин хийх зорчигч тээвэрлэлт

4.1.7

орон нутгийн зорчигч нийтийн /АТҮТ/ тээвэрлэлт

тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт хийх зорчигч тээвэрлэлт

4.1.8

хотын доторх зорчигч нийтийн /АТҮТ/ тээвэрлэлт
тухайн хотын нутаг дэвсгэр дотор хийх зорчигч тээвэрлэлт

4.1.9

хот орчмын зорчигч нийтийн /АТҮТ/ тээвэрлэлт
тухайн хот, дагуул дүүрэг, алслагдсан суурьшлын нутаг дэвсгэрийг дамжин хийх зорчигч тээвэрлэлт

4.1.10

нийтийн зорчигч нийтийн /АТҮТ/ тээвэр
эрх бүхий байгууллагаас тогтоосон замнал чиглэл /АТҮТ/, хөдөлгөөний цагийн хуваарийн дагуу зохион байгуулалттай гүйцэтгэх зорчигч тээвэрлэлт

4.1.11

тээвэрлэгч
эрх бүхий байгууллагатай нийтийн зорчигч /АТҮТ/ тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэн /АТҮТ/

4.1.12

замнал чиглэл /АТҮТ/
зорчигч тээвэрлэх чиглэлийн эхний ба эцсийн зогсоолуудын хоорондох батлагдсан зам.

4.1.13

хөдөлгөөний цагийн хуваарь
нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дэглэмийг тогтоосон баримт бичиг

4.1.14

замналын чиглэлийн /АТҮТ/ зураглал нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн замналын дагуу явах хөдөлгөөний зураг

4.1.15

нийтийн зорчигч /АТҮТ/ тээврийн жолооч
нийтийн зорчигч тээврийн хэрэгслийг жолоодох зохих ангилалын жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй, нийтийн зорчигч /АТҮТ/ тээврийн хэрэгслийн жолоочоор ажиллаж байгаа этгээд

4.1.16

нийтийн зорчигч тээврийн кондуктор
нийтийн зорчигч тээврийн кондукторын мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ, үнэмлэх авч, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа этгээд /АТҮТ/

4.1.17 зорчигч урсгал

нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд нэгж хугацаанд, **нэг рейсэнд /ХХТЭХ/** тээсэн зорчигчдын тоо

4.1.18 захиалгат үйлчилгээ

тодорхой орон зай, цаг хугацаанд олон нийтийг хамарсан, зохион байгуулалттайгаар гүйцэтгэх зорчигч тээвэрлэлт.

5 Үйлчилгээнд тавих шаардлага

5.1 Нийтийн зорчигч тээвэрлэлтийг гүйцэтгэх нутаг дэвсгэрийн хүрээнээс хамааруулж дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Улс хоорондын зорчигч **нийтийн /АТҮТ/** тээвэрлэлт,
2. Хот хоорондын зорчигч **нийтийн /АТҮТ/** тээвэрлэлт,
3. Орон нутгийн зорчигч **нийтийн /АТҮТ/** тээвэрлэлт,
4. Хотын доторх зорчигч **нийтийн /АТҮТ/** тээвэрлэлт,
5. Хот орчмын зорчигч **нийтийн /АТҮТ/** тээвэрлэлт,

5.2 Хотын доторх болон хот орчмын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, зорчигч урсгалын хэмжээ болон замналын хөдөлгөөний дэглэмээс хамаарч дараах төрөл байна. Үүнд:

1. Ердийн
2. Буухиа /экспресс/

5.2.1 Хөдөлгөөний ердийн дэглэмийн үед нийтийн тээврийн хэрэгсэл нь **замналын чиглэлийн /АТБХЗГ/** дагуух бүх зогсоолд заавал зогсоно.

5.2.2 Хөдөлгөөний буухиа дэглэмийн үед нийтийн тээврийн хэрэгсэл нь **замналын чиглэлийн /АТБХЗГ/** дагуух урьдчилан тогтоосон зогсоолуудад зогсоно.

5.3 Захиалгат үйлчилгээ гүйцэтгэх нийтийн тээврийн хэрэгсэл нь тусгай хаягтай байна.

5.4 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн үйлчилгээнд хурд хэтрүүлэх, багтаамжаас илүү хүн шахаж суулгах, зогсоол дээр нийтэд хашгирч зарлахыг хориглоно.

5.5 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн үйлчилгээг техникийн хувьд бүрэн, иж бүрдэлтэй, хөдөлгөөний болон экологийн аюулгүй ажиллах нөхцөлийг хангасан нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

5.6 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн хэрэгслийн (том оврын, автобусны) зориулалтын хаягийн сууринд замналын нэр, дугаар, эцсийн ба дундын зогсоолуудын нэрийг нийтэд мэдэгдэхээр бичиж байрлуулсан, мөн хаалга нь зорчигч орох, гарах тэмдэгтэй байна. Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл нь зориулалтын бүрэн бүтэн суудал, бариул, зорчигчдын заал нь бүрэн ажиллагаа бүхий гэрэлтүүлэх ба дулаацуулах систем, үйлчилгээний зарлал, мэдээллийн хэрэгсэлтэй байна.

5.7 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн хэрэгслийн багтаамжаас илүү хүн суулгах, зорчигчийн зааланд 5.7.1, 5.7.2-д зааснаас хүнд, овор ихтэй ачаа, тээш авч явахыг **зөвшөөрөхгүй болно хориглоно /АТБХЗГ/**.

5.7.1 Зорчигчийн гар ачаа нь 60 см × 30 см × 20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 15 кг-аас хэтрэхгүй жинтэй байна.

5.7.2 Улс, хот, аймаг хооронд, орон нутгийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн хэрэгслээр зорчигчийн гар ачаа нь 60 см х 40 см х 20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 20 кг-аас хэтрэхгүй жинтэй байна.

5.7.3 Гар ачааг зорчигч автобусанд биедээ авч явахыг зөвшөөрнө.

5.7.4 Зорчигчийн 60 см × 40 см × 20 см-ээс илүү овор хэмжээтэй тээшийг автобусны тээшний хонгилд юмуу ачааны тусгай автомашинаар тээнэ.

5.8 Нийтийн **зорчигч /АТБХЗГ/** тээвэрлэлтэд биеэ авч явах чадваргүй хүнд өвчтөн, сэтгэл мэдрэлийн өвчтэй, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зөвхөн асран хамгаалагч хүнтэй явахыг зөвшөөрнө.

5.8.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, нялх хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхэд, өндөр настан зэрэг хүмүүсийг нийтийн **зорчигч /АТБХЗГ/** тээврийн хэрэгсэлд орох ба буух, суух, зорчих үед нь жолооч, **кондуктор /АТБХЗГ/**, бусад зорчин явагчид анхаарал тавьж тусална.

5.9 Нийтийн **зорчигч** тээврийн хэрэгсэл дотор замналын **чиглэлийн /АТБХЗГ/** зураг болон тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг, заалт, бусад санамжуудыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан байна.

5.10 Нийтийн **зорчигч /АТБХЗГ/** тээврийн хэрэгсэлд тасалбар авахгүй байх, зориулалтын бус хаалгаар орж гарах, дарааллын журам баримтлахгүй дайрч орж болохгүй. Мөн хамгаалалтгүй нохой амьтан тээх, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис, буу зэвсэг, эвгүй үнэртэй, зорчигчдын хувцсыг бохирдуулах, биед нь гэмтэл учруулж болох эд зүйл авч явахыг хориглоно. Зайлшгүй тохиолдолд бусдад үзүүлэх хор нөлөөллийг бүрэн арилгасан байна.

6 Нийтийн **зорчигч /АТБХЗГ/** тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тавих ерөнхий шаардлага

6.1 Нийтийн **зорчигч /АТБХЗГ/** тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн (цаашид тээвэрлэгч гэнэ)-д дараах шаардлагыг тавина. Үүнд:

6.1.1 Тээвэрлэгч нь нутаг дэвсгэрийнхээ бүртгэх байгууллагад тогтоосон журмын дагуу бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

6.1.2 Ажил үйлчилгээний төрөл, үйл ажиллагаа явуулах хугацааг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн байгуулах гэрээнд тодорхой заасан, хүчин төгөлдөр байна.

6.1.3 Аж ахуйн болон бизнесийн үйл ажиллагааг эрхлэн удирдах, төлөөлсөн эрх бүхий этгээдийн овог нэр, хаяг, регистрийн дугаарыг **нотариатын газраар нотариатаар /АТБХЗГ/** баталгаажуулсан байна.

6.2 Тээвэрлэгч нь өөрийн **болон түрээс, хамтын эзэмшлийн /ХХТЭХ/** өмчийн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын дараах барилга байгууламжтай байна. /энэ заалтыг 2013 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөнө/ Үүнд :

- 1) Техникийн оношлогоо, үйлчилгээ, засварын байр
- 2) Дулаан зогсоол (Нийт паркийн 80,0-аас багагүй хувийг дулаан гараашид хадгална.)
- 3) Ил зогсоол талбай

6.2.1 Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний байр, дулаан гараашийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмж нь БНБД 2.08 02 нормд заасан шаардпагуудыг хангасан, автомашины

хөдөлгүүрийн ажилласан хийг зайлуулах, мөн агааржуулах гэрэлтүүлэх, дулаалцуулах систем, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, хэвийн ажиллагаатай байна.

6.2.2 Энэ стандартаар **20 25 /АТҮТ/** хүртэлх автобусанд техникийн оношлогоо, үйлчилгээ, засварын тоногдсон суваг эсвэл өргүүр нэг байна.

6.2.3 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн хэрэгслийн техникийн оношлогоо, үйлчилгээ, засварын байр, дулаан гарааш нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд :

6.2.3.1 Тээврийн хэрэгслийн угаалгын цэгтэй байна.

6.2.3.2 Бие засах газар, технологийн болон хэрэглээний халуун ус, ажилчдын хувцас солих болон амрах байртай байна.

6.2.3.3 Галын аюулгүйн шаардлагын дагуу галын цэгийг төлөвлөж байгуулсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбосон байна.

6.2.4 Ил зогсоолын зам, талбай нь үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн урсгалыг хангасан цардмал, нийт тээврийн хэрэгслийн 80-аас доошгүй хувь нь зогсох хэмжээтэй байна. Явган хүний хатуу хучилттай замтай байна.

6.3 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн хэрэгслийн жолооч, кондукторын ажил, амралтын дэглэмийг Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу зохицуулна.

6.4 Хөдөлгөөний болон бусад болзошгүй осол, аюулын үед холбогдох байгууллага, хүмүүст яаралтай мэдэгдэх, осол аюулд өртөгсдөд анхны тусламж үзүүлэх, аврах, шаардлагатай арга хэмжээ авахуулах ажлыг зохион байгуулна.

6.5 Тээвэрлэгч нь байгууллагын тусгайлсан таних эмблемтэй байна.

6.6 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн хэрэгсэл бүрийг угаах, цэвэрлэх, арчих хэрэгсэл, материалаар хангасан байна.

6.7 Жолооч нарыг эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт жил бүр хамруулна. Өдөр бүр үйлчилгээнд гаргахын өмнө жолооч нарыг тээврийн хэрэгсэл жолоодох чадварын үзлэгт /цусны даралт, **зүрхний хэм, сахарын хэмжээ, амарсан байдал, /ХХТЭХ/** согтуу болон мансуурсан эсэх /оруулсан байна.

6.8 Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн үйлчилгээнд ажиллагсадыг ажлын хувцас (халат) өөрийн нь зураг, нэр бүхий нэрийн хуудастай ажиллуулна.

6.9. Нийтийн зорчигч **/АТБХЗГ/** тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг механик нь MNS 4598: **2011 /АТБХЗГ/** стандартын дагуу шалгаж, үйлчилгээнд гарах бүрт нь үйлчилгээний даалгаврын хуудсанд тэмдэглэсэн байна.

7 Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэлд тавих шаардлага

7.1 Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл нь зорчигчдын ая тухтай, аюул осолгүй зорчих, аялах нөхцөл бүрдсэн, техникийн хувьд бүрэн бүтэн, "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага" MNS 4598: 2011 стандартад заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

7.2 Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн хэрэгсэлд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн болон нялх хүүхэдтэй эхчүүдэд зориулсан суудал гаргаж, тусгайлсан тэмдэглэл тавьж үйлчилнэ.

7.3 Нийтийн зорчигч тээврийн бага оврын /АТБХЗГ/ автобусанд дараах нэмэгдэл шаардлагыг тавина. Үүнд:

7.3.1 Харьяалах аж ахуйн нэгж, байгууллагын эмблем, гараашийн дугаар, чиглэлийн нэр, дугаарыг баталсан загварын дагуу зорчигчдод ил тод харагдах газар бичиж байрлуулна.

7.3.2 Бага оврын автобусны Нийтийн тээврийн хэрэгслийн /АТҮТ/ хоёр хажуу талд "Нийтийн зорчигч тээвэр" гэсэн бичээс бүхий туузыг тээвэрлэлтийн төрлөөс хамаарч ялгах тууз эсвэл паркийн дугаарыг /АТҮТ/ нийтэд тод харагдахаар бичиж байрлуулна. Үүнд:

Туузын хэмжээ: Урт 2200 мм, өргөн 180 мм

Үсэгний хэмжээ: Өндөр 100 мм, өргөн 50 мм

Дэвсгэр өнгө: Шар

Үсэгний өнгө: Хөх

Чиглэлийн хаягийн хэмжээ: Урт 400 мм, өргөн 200мм

Үсэгний өнгө: Хар

Дэвсгэр өнгө: Туслах чиглэлд шар,

Буухиа чиглэлд ногоон

Ялгах туузын бичиглэл:

"Хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ"

Том оврын тээврийн хэрэгсэлд:

Туузын хэмжээ: Урт 3000 мм, өргөн 250 мм үсэгний хэмжээ: өндөр 150 мм, өргөн 50 мм

Дунд, бага оврын тээврийн хэрэгсэлд

Туузын хэмжээ: Урт 2200 мм, өргөн 180 мм

Үсэгний хэмжээ: өндөр 100 мм, өргөн 50 мм

Дэвсгэр өнгө: Шар /код: 100/

Үсэгний өнгө: Хар /код: тас хар/

Чиглэлийн хаягийн хэмжээ:

Хот хоорондын нийтийн тээвэр: Урт 800 мм, өргөн 200мм

Үсэгний өнгө: Хар /код: тас хар/

Дэвсгэр өнгө: Шар /код: 100/ /АТҮТ/

7.4 Нийтийн зорчигч /АТБХЗГ/ тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэснээс хойш 12-оос (~~такси 8, дунд оврын автобус 12, том оврын автобусанд 15-аас~~) /ХХТЭХ/ дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно.

7.5⁵ Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч /АТБХЗГ/ тээврийн автобус, троллейбусанд харьяалах аж ахуйн нэгж, байгууллагын эмблем, гараашийн дугаар, чиглэлийн нэр, дугаарыг баталсан загварын дагуу зорчигчдод ил тод харагдах газар бичиж байрлуулна. Үүнд:

— Гараашийн дугаарыг автобусны хоёр хажуу, ар талд болон дээвэр дээр,

— Чиглэлийн хаягийг урд, хоёр хажуу талд цахим болон бусад хэлбэрээр бичиж байрлууна.

7.6 Нийтийн зорчигч /АТБХЗГ/ тээврийн үйлчилгээний чанар, соёл, эрүүл ахуйн шаардлага

7.6.1 Тээвэрлэгч нь үйлчлэх замнал ба уг замналын эцсийн болон дундын зогсоолд, хөдөлгөөний цагийн хуваарь, тээвэрлэлтийн зай, хоногт гүйцэтгэх рейсийн тоо зэрэг замналын үзүүлэлтүүдийг төлөвлөж баталгаажуулсан байна. Үйлчилгээний үнэ, хөлсний талаар нийтийн зорчигч тээврийн зохицуулах эрх бүхий байгууллагатай зөвшилцөнө.

7.6.2 Тээвэрлэгч нь үйлчлэх замналд зорчигчдыг аюул осолгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрэн хангаж хөдөлгөөний чиглэл, цагийн хуваарийг чанд баримтлан ажиллахын зэрэгцээ хот хооронд нийтийн тээврийн үйлчилгээний тодорхой цэгүүдэд жолооч, кондукторын түр амрах, хооллох байр, бие засах газруудыг “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж. Үндсэн шаардлага” MNS 5537 стандартын дагуу зохион байгуулна.

7.6.3 Үйлчилгээний явцад замд эвдэрсэн тээврийн хэрэгсэлд техникийн түргэн тусламж үзүүлэх, үйлчилгээний хяналт зохицуулалт хийх, тээвэрлэлтийн мэдээ, мэдээлэл өгөх, авах зориулалтын холбоо, мэдээллийн хэрэгслээр хангасан байна.

7.6.4 Нийтийн тээврийн хэрэгслийн дотор, гадна талыг угааж, зорчигчдын суудал, түшлэг, бариул зэргийг арчиж цэвэрлүүлэн үйлчилгээнд гаргана.

7.6.5 Нийтийн зорчигч /АТБХЗГ/ тээврийн үйлчилгээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, техникийн, галын, хөдөлгөөний болон экологийн аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг холбогдох стандартад заасан үзүүлэлт, шаардлагыг хангасан байна.

8 Хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага

8.1 Нийтийн зорчигч /АТБХЗГ/ тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын техникийн асуудлыг шууд эрхлэн удирддаг албан тушаалтан нь авто тээврийн мэргэшсэн инженерийн сургалтанд хамрагдаж үнэмлэх, гэрчилгээ авсан байна.

8.2 Жолооч

8.2.1 Жолооч нь ерөнхий боловсролын суурь болон бүрэн дунд боловсролтой, автобусны жолооч бэлтгэх тусгай дамжаа дүүргэсэн, жолоочийн мэргэжлийн "Д" ангилалтай, тээвэрлэгч жолоочоор мэргэшсэн 21-ээс дээш насны хүн байна. **замын хөдөлгөөний дүрмийн дагуу “Д ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй, 23-аас дээш настай, мэргэшсэн жолоочийн 21 хоногийн сургалтад хамрагдаж мэргэшсэн жолоочийн үнэмлэх авсан, эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт хамрагдсан байна. /АТҮТ/**

8.2.2 Нийтийн тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдал, өнгө үзэмж, ариун цэвэр, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, шил арчигч, бусад төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцна.

8.2.3 Шугамд гарахын өмнө тээврийн хэрэгслийг техникийн ерөнхий үзлэг хийж үйлчилгээнд гарах ба шугамаас буухдаа тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгах механикчаар шалгуулна.

8.2.4 Ажлын шаардлагын үүднээс хөдөлгөөний цагийн хуваарьт өөрчлөлт орсон үед диспетчерийн хийсэн зохицуулалтыг бүрэн биелүүлнэ. Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөний бүртгэл, хяналтын системийн хөдөлгөөнт дамжуулах станцын ашиглалтын журмыг зөрчихгүй байх, эвдрэлтэй үед үйлчилгээнд гарахыг хориглоно.

8.2.5 Замналын дагуух зогсоолд зогсохдоо “зогсоолын талбай”-н эхэнд зорчигч замын хашлагаас автобусанд суух боломжтой зайд зогсож, зорчигчдыг бүрэн бууж, суусны дараа хаалгаа хааж, хөдөлгөөний аюулгүй байдал хангагдсаны үндсэнд хөдөлгөөнийг эхлэх, шаардлагатай гэж үзвэл жолооч зорчигчдод хөдөлгөөн эхлэхийг анхааруулна. ~~Жолооч дараагийн зогсоолын нэрийг заавал зарлана.~~ **/АТҮТ-Сутайн буянт ХХК/**

8.2.6 Оройн ээлжинд ажилласан жолооч ээлжээс буухдаа шаардлагатай шатахуун, тослох материалыг бүрэн авч, автобусыг цэнэглэн зохих гарааш, зогсоолд тавина.

8.2.7 Гараашаас гарахдаа байгууллагын диспетчерт жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг шалгуулж, тээврийн даалгаврын хуудсаа авна. Хот хоорондын зорчигч тээвэрлэлтэд шугамын зохицуулалтын диспетчерт рейс тутмын ажлын гүйцэтгэлээ тэмдэглүүлж, төгсгөлд нь хаалгана.

8.2.8 Үйлчилгээний үед тээврийн хэрэгсэлд учирсан техникийн эвдрэл, гэмтлийн талаар холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, техникийн түргэн тусламж авах, эвдрэлийг арилгуулах, зорчигчийг шилжүүлэн суулгах яаралтай арга хэмжээ авна.

8.2.9 **Улс, хот** хоорондын ~~зөрчигч~~ **нийтийн /АТБХЗГ/** тээврийн хэрэгслийн жолооч нь ~~кондукторгүй ажиллах үед~~ **/АТҮТ/** зорчигчийн заалны доторх үйлчилгээ, дэг журам хангуулах ажлыг хариуцна.

8.2.9¹ **Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг холын чиглэлд /600 км-ээс дээш/ болон шөнийн цагаар тээвэрлэлт гүйцэтгэх шаардлага гарсан тохиолдолд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс ээлжийн жолоочтой байна. /АТҮТ/**

8.2.10 Нийтийн ~~зөрчигч~~ **/АТБХЗГ/** тээврийн жолооч нь үйлчилгээний явцад дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

8.2.10.1 Хөдөлгөөний үед жолоочийн бүхээгт хүн суулгах, тамхи татах, гар утсаар ярих, зорчигчдын танхимд дуу хөгжим чанга тавих.

8.2.10.2 Хурд хэтрүүлэх, зогсоолын бус газарт хүн буулгах ба суулгах.

8.2.10.3 Чиглэлийн зөвшөөрөгдсөн замаас хазайж өөр зам, замналаар сэлгүүцэх, зорчигч тээвэрлэх, хөдөлгөөний цагийн хуваарь зөрчих.

8.2.10.4 Хүндэтгэх шалтгаангүйгээр нийтийн тээврийн хэрэгслийг огцом тоормослож гэнэт зогсоох, хөдлөх зэргээр зорчигчдын тав тухыг алдагдуулах.

8.2.10.5 Зайлшгүй шаардлагатай буюу зохих байгууллагын зөвшөөрснөөс бусад зураг, зарлал, сурталчилгааны ухуулах хуудас зэргийг нийтийн тээврийн хэрэгсэлд байрлуулах.

8.2.10.6 Жолооч нь байгууллагын хариуцлагатан нарт зорчигч тээврийн үйлчилгээний шаардлага хангаагүй автобусаар үйлчилгээ явуулах боломжгүйг мэдэгдэх үүрэгтэй.

8.2.10.7 Үйлчилгээний явцад тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж, эд хогшлыг гэмтээсэн, зорчигчдыг тав тухтай зорчиход саад учруулсан, бусдын эрх чөлөөнд халдаж, танхайрсан зэрэг зөрчлийн үед хөдөлгөөнийг зогсоож, шаардлагатай арга хэмжээ авах.

8.3 Кондуктор

8.3.1 Кондуктор нь ерөнхий боловсролын суурь болон бүрэн дунд боловсролтой, 18-аас дээш настай, эрүүл мэндийн шаардлага хангасан, тээвэрлэгч кондуктораар мэргэшсэн хүн байна.

8.3.2 Кондуктор соёлч боловсон харьцаатай, зарчимч шаардлагатай, үнэнч шударга ажиллаж, зорчигчдод хөнгөн шуурхай, үйлчилнэ.

8.3.3 Кондуктор нь жил бүр эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт орж, шаардлагатай үед эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж байна.

8.3.4 Кондуктор нь цэвэр үзэмжтэй хувцаслаж, байгууллагын таних тэмдэг бүхий ажлын хувцас /халад/ тай, өөрийн зураг, нэр бүхий энгэрийн хуудас зүүсэн байна.

8.3.5 Ажилд гарахын өмнө нийтийн тээврийн хэрэгслийн цонх, хана, шал,, зорчигчийн суудал, түшлэг, бариул зэрэгт чиигтэй цэвэрлэгээ хийж, хөг, шөрөө төөс, тосыг бүрэн цэвэрлэнэ.

8.3.6 Тухайн ээлжинд хүрэлцэх зөрчих тасалбар, тийзийг бэлтгэж ажилд гарна.

8.3.7 Өдрийн орлогыг байгууллагын санхүүд өдөрт нь тушааж өмчийн зөрчилгүй ажиллана.

8.3.8 Зорчигчдоос тогтоосон тарифын дагуу зөрчих хөлсийг хурааж авах ба түүнд тохирсон үнэ бүхий тасалбарыг зорчигчийн өмнө урж хүчингүй болгож өгнө.

8.3.9 Зорчигчдод цаг агаарын хэвийн болон бороо, цастай, үзэгдэх орчин муу үед ирсэн болон дараагийн буудлыг заавал мэдээлнэ.

8.3.10 Кондуктор нь үйлчилгээний явцад дараах үйлдлийг гаргаж болохгүй.

8.3.10.1 Зорчигчидтой ширүүн догшин харьцах, элдэв муу үгээр дайрч доромжлох, эрхэнд нь халдах зэрэг соёлгүй байдал гаргах.

8.3.10.2 Зураг, овог нэр бүхий үйлчилгээний нэрийн хуудсаа зүүхгүй үйлчлэх.

~~8.3.10.3 Тасалбар өгөхгүйгээр зорчигчдоос мөнгө хурааж авах, тасалбарыг хүчингүй болгохгүйгээр зорчигчдод өгөх.~~

9 Зорчигчдод тавих шаардлага

~~9.1 Тээврийн хэрэгслийн хойд хаалгаар орж, дунд болон урд хаалгаар бууна. Хот доторхи тээврийн хэрэгслийн урд хаалгаар орж, зорчих картаа төхөөрөмжид уншуулж, буухаас өмнө картаа хойд хаалганы төхөөрөмжид уншуулсны дараа бууна. /АТҮТ-Сутайн буянт ХХК/~~

9.2 Нийтийн тээврийн хэрэгсэлд дарааллыг баримтлан бие биедээ саад болохгүйгээр сууж, буух ба ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэдтэй хүмүүсийг хүндлэн дугаарын эхэнд сууж, буухад тусална.

~~9.3 Нийтийн тээврийн хэрэгсэлд суугаад дараагийн буудалд хүрэхийн өмнө шаардуулахгүйгээр зорчих хөлсөө төлж тасалбараа авсан байна. Үнэгүй буюу хөнгөлөлттэй үнээр зорчих тохиолдолд зорчигчид эрхийн үнэмлэх, сарын байнгын билет зэргийг кондукторт үзүүлнэ.~~ **Зорчигч нь нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо автобусанд суусан даруйдаа жолооч болон шалгагчаар шаардуулахгүйгээр төхөөрөмжид картаа уншуулан зорчих хөлсөө төлнө. Бэлэн мөнгөтэй тохиолдолд дараагийн зорчигчтой тохиролцон хамт зорчино. Бэлэн мөнгөөр зорчих, хөлс төлөхгүй зорчихыг хориглоно. /АТҮТ-Сутайн буянт ХХК/**

~~9.4 Зорчигч нь нийтийн тээврийн хэрэгсэлд суусан даруйдаа хөлсөө төлж, гарах хаалганд ойртон, бусдад аль болох саад болохгүйгээр зорчиж, тээврийн хэрэгсэл бүрэн зогссоны дараа бууна.~~ **Зорчигч нь автобусыг бүрэн зогссоны дараа сууж, бууна. Зорчигч нь гэнэтийн эрсдлээс өөрийгөө хамгаалж зорчино. /АТҮТ-Сутайн буянт ХХК/**

9.5 Нийтийн тээврийн хэрэгслийн доторх тоноглол, бусад төхөөрөмж, зорчигчийн суудал, түшлэг, бүрээс, бариул зэрэгт өөриймсөг, хайр гамтай хандана.

9.6 Зорчилтын хөлс төлөөгүй үедээ кондукторын анхны шаардлагаар хөлсөө төлөх буюу зохих бичиг баримтаа үзүүлнэ.

9.7 Зорчих хөлс төлөхгүй маргалдсан, танхайрсан хүмүүст бурууг нь ойлгуулахад кондуктор, жолооч нарт хажуугийн зорчигчид дэмжлэг үзүүлж туслана.

9.8 Согтуу хүмүүст үйлчлэхгүй байх талаар жолооч, кондуктор нарт шаардлага тавина.

9.9 Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчид нь өөрийн амь насыг даатгуулсан байна.

9.10 Зорчигчдод дараах үйлдлийг хориглоно. Үүнд:

9.10.1 Хөлс төлөхгүйгээр зорчих.

9.10.2 Нийтийн тээврийн хэрэгсэлд чанга ярьж хашгирах, бусадтай маргалдах, инээлдэх зэргээр бусдын амгалан тайван байдалд нөлөөлөх.

9.10.3 Нийтийн тээврийн хэрэгслийн хаалганаас зүүгдэх, хөдөлгөөн эхлэх дохио өгснөөс хойш суух.

9.10.4 Зорчигч тээврийн хэрэгслийн эд анги, сандал, түшлэг, бүрээсийг гэмтээх, тамхи татах, хог хаях (самрын яс, тамхины иш, тасалбар), жолоочтой ярьж анхаарлыг нь сарниулах зэрэг зохисгүй үйлдэл гаргах.

ТӨГСӨВ.